

Шинжааны “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэх
шидэт үлгэр чоно тотемтой холбогдох нь

Д.УРАНЧИМЭГ*

БНХАУ, Өвөр Монголын Хөлөнбуйр Дээд Сургууль
Үндэстний түүхийн сурвалж бичиг судлах төв

Received: Jun 25, 2024

Revised: Jul 23, 2024

Accepted: Aug, 21, 2024

Хураангуй: Шинжааны өөлдийн шидэт үлгэр дэх “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэдэг үлгэр нь хүн хийгээд ондоо төрөлтөн урагласан домгийн мотивоо улиран хөгжиж, бусад үлгэрийн мотивтой нийлж нийлмэл үлгэр болсон байна. Үүний үндэс сурвалж ба улирсан явцыг хайн сүвэгчлэхэд юуны урьд монгол, түрэг хэлтний овог угсаатны үүсэл гарлыг тайлбарласан домгуудын мотивоос гардан шинжилнэ. Дараа нь Шинжааны өөлдийн шидэт үлгэр дэх “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэдэг үлгэрийн хувилбаруудад хэв шинжийн задлан шинжилгээ хийж хүн ондоо төрөлтөнтэй урагласан домгийн мотив нь гол байснаа үргэлжилж угийн онцлогоо алдан явган үлгэрийн шинжтэй болсныг харуулна.

Түлхүүр үг: шидэт үлгэр, хэв шинж, домгийн мотив, онцлог, явган үлгэр, чоноос эхнэр авах, хувилбар

“The boy took a wife from wolf”

URANCHIMEG.D

Center for textology of National history, khulunbuir
university, Inner Mongolia, China

Abstract: The Oirat magical tale “The boy took a wife from wolf” from Shinjang has evolved from the mythic motif of a human marrying a non-human being and has merged with other folktale motifs, becoming a composite tale. In tracing its origins and developmental process, the study first conducts a detailed analysis of motifs

* © Д.Уранчимэг Тус өгүүлэл нь Өвөр Монголын Хөлөнбуйрын дээд сургуулийн 2023 оны “Залуу докторыг дэмжих төсөл”-ийн хүрээнд бичив. Төслийн нэр: “Шинжааны монгол үндэстний шидэт үлгэрийн хэв шинж ба товъёг”. Төслийн дугаар: 2023BSJJ19)

Email: Duomanwurenqimike@163.com

from myths that explain the origins of Mongolic and Turkic-speaking ethnic groups. Then, a structural analysis of different versions of “The boy took a wife from wolf” within Shinjang Oirat magical tales is conducted. The findings illustrate that while the original motif of a human marrying a non-human being remained central, over time the tale lost its mythological essence and transformed into an ordinary folktale.

Key words: *Took a wife from wolf, Motif Variations; Origin and Transformation of the Motif*

Удиртгал

Нийгмийн хөгжлийг дагаж уугуул иргэдийн өөрийн биеийн ухамсар зохих хэмжээгээр дээшлэхийн сацуу угийн хүн амьтан шууд харьцаа үүсч хүмүүн төрөлхтөн үүссэн гэх домог нь тухайн хүмүүсийн ертөнцийг үзэх үзлийн логик сэтгэхүйтэй аяндаа нийцэхгүй болж, ингээд уулын домог дахь амьтан нь үс арьсаа хаяж хүмүүн болон хувилан ураг холбох үлгэр болон хөгжжээ (Тиез Ань, 2007: 66-67). Шинжааны өөлдийн “ондоо төрөлтөнтэй урагласан” үлгэрт олонх байдалд амьтан нь арьсаа хаяж хүмүүний дүртэй болж хувиран, хүмүүн төрөлтөнтэй урагладгаар яригддаг. Өөрөөр хэлбэл, уулын домогт хүмүүн, амьтан шууд харьцаа үүсэж байсан бол үлгэрт амьтнаас хувилсан хүмүүнтэй ураг холбох болсон гэлтэй. Шинжааны өөлдийн шидэт үлгэр дэх “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэх шидэт үлгэр их сонирхолтой. Энэ үлгэр нь монгол ба алтай язгуурын хэлт үндэстний өвөг дээдсийн үүсэл домогтой нягт холбоотой бөгөөд чонын тотем шүтлэгтэй холбоотой.

Үндсэн хэсэг

Нэг. Шинжааны өөлдийн “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэх шидэт үлгэрийн хувилбарууд

Шинжааны өөлдийн шидэт үлгэр дэх “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэх үлгэр нь Дин Най дүнгийн “Дундад Улсын явган үлгэрийн хэв шинжийн товьёг”-ийн 400D номерт жагсаагдаж байгаа “бусад амьтнаас хувирсан эхнэр” гэх гэв шинж болон Жинь Рун хуагийн “Дундад улсын явган үлгэрийн чуулганы хэв шинжийн товьёг”-ийн 400D номерт жагсаагдаж байгаа “амьтнаас хувирсан эхнэр” гэх гэв шинж, Ху Вэнь чуаний “Тайванийн явган үлгэрийн хэв шинжийн товьёг”-ийн 400*** номерт жагсаагдаж байгаа “бусад амьтнаас хувирсан эхнэр” гэх гэв шинжид орж байна.

Шинжааны өөлдийн дунд “Чоноос авгай авсан хөвүүн” (Дамринжав, 274-279), “Чоно эхнэртэй хөвүүн” (Дамринжав, 268-273), “Эмгэн хөгшин хоёрын хөвүүн” (Дамринжав, 264-267) “Эргүү мунхаг хаан” (тод) (1992 оны 5 сар, 57-65), “Баяны хөвүүн болон чоно” (тод), (Хан тэнгэр, 1991 он 4 дүгээр хугацаа) гэх мэтийн хувилбарууд уламжлагдсан байдаг. Эдгээр үлгэрийг тус тусад нь англи хэлний цагаан толгойн том үсэг А, В, С, D, Е-ээр төлөөлүүлж, хувилбаруудын тухай хэв шинжийн үйл явдлын үндсэн бүтцийг нь дөхөм байдлаар танилцуулбал:

Таван хувилбарын үйл явдлын хэв шинжийн бүтэц нь хоорондоо нийтлэг талтай мөртлөө бас өвөрмөц талтай. Тухайлбал, дээрх таван хувилбарын нийтлэг өгүүлэмж нь:

Тухайн таван хувилбарын үйл явдлын үндсэн бүтэц нь:

- А Эрт урд цаг буюу хэзээний цагт, нэг баян эсхүл нэг эмгэн хөгшин хоёр гагц хөвүүнтэй санжээ гэнэ.
- В Нэг баян эсхүл нэг эмгэн хөгшин хоёрын хөвүүн адууг нь татсан чоныг алах гэхэд, тэр чоно хүний хэлээр хэлж хөвүүнийг гэртээ залдаг.
- С Цагаан аав эсхүл чоно ээж, чоно бэргэн тохируулснаар чоно дүртэй хүүхэнтэй хуримлаж айл гэр болжээ.
- Д Нутгийн хаан ав хийж явж байтал авлаж байгаа шувуу нь хөвүүний гэр дээр буухад, хаан шувуугаа авахаар хөвүүний гэрт ороход нэг гоё эхнэр байдаг гэнэ. Тэгээд хаан, хөвүүний эхнэрт дурлаж хөвүүнийхээ эхнэр болгох буюу өөрийн хатнаа болгох гэж хуйвалдаж арга сүвэгчилнэ.
- Е Хөвүүн эхнэр болон хадам аав эсхүл эхнэр болон хадам ээж, бэргэнийхээ тусламжаар хааныг ялж, хаан сууринд сууж амар сайхан жаргаж суудаг.

Дээр дурдсан таван хувилбарын үйл явдлын хэв шинжийн үндсэн бүтэц нь өөр хоорондоо нийтлэг талтай мөртлөө бас өвөрмөц талтай байдаг. Дээрх таван өгүүлэмж бол таван хувилбарт цөм яригддаг нийтлэг өгүүлэмжүүд болох мөртлөө нэлээд тогтвортой байдаг. Гэвч адил бус үлгэрчийн үлгэр ярих авьяас ур чадвараас болж, зарим нэгэн өгүүлэмж нь хоорондоо ялгаа зөрөөтэй болсон байдаг. Жишээлбэл: А болон Е хувилбарт бүр л баяны хөвүүн болон чоно гэж байхад, В, С, D хувилбарт харин өвгөн эмгэн хоёрын хөвүүн болон чоно гэх мэтээр яригддаг. Зарим үес нэг үлгэрт ямар нэг өгүүлэмж нь солигдож, өөр үлгэрийн өгүүлэмжүүдэд холигдон яригддаг нь зөндөө харагддаг. А болон Е хувилбарт хаан хөвүүний гоё сайхан алтан дагинаар хатнаа болгох гэж хөвүүнтэй хоёр буюу гурван мөрий тавих нь яг сайхан монгол үндэстний эрийн гурван наадмын бас нэг зүйлийн хэлбэр болж байна. Энэ нь нэг үндэстний суурьшин сууж байгаа газар орны онцлог хийгээд тухайн газрын үлгэрчийн үлгэр ярих ур чадвараас шалтгаалсан юм. Нэг үлгэрийн уламжлал нь тухайн орон нутгийн аж ахуй болон соёлын орчин тойрон зэрэг шалтгаанаас болж өвөрмөц онцлогтой болдог. Үлгэрчийн сонирхол нь үлгэр уламжлахын гол нэгэн шалтгаан болно. Өөрөөр хэлбэл, үлгэр ярих хүнд түүний ярих дур сонирхолтой үлгэр байдаг буюу адил бусын сонсогч этгээдээс шалтгаалж ярих үлгэрээ тэдэнд зохицуулан ярьдаг.

Хоёр. Хүмүүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан мотивийн үүсэл, хөгжил

Домгийн мотив бол тухайн цаг үеийн хүмүүсийн нийгмийн амьдралын арга хэлбэр, байгалийг таньж мэдсэн танилт, баларлаг сэтгэц, ураг хуримын

байдал зэргийг тусган харуулдаг өөрийн үүсэл хөгжлийн түүхтэй. Тэр нь балар эртний хүмүүсийн нялхсаг бодлоороо үүсэл гарлаа тайлбарлахыг дагалдан аяндаа бий болсон байдаг. Эгчлэлийн овог төрлийн нийгмийн бий болохыг дагалдан хүмүүс өөрийн үүсэл гарлыг мэдэх гэсэн эрэмзлэл тэмүүллийн дунд өөрийн биеэ байгалийн ямар нэгэн амьтан ба бодис, ургамал зэрэгтэй холбон домоглож, угсаа гарлаа тайлбарласнаас домог буюу домог яриа нь бий болсон гэлтэй.

Хүмүүн хийгээд ондоо төрөлтөн урагласан мотив бол хүмүүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан угсаатны үүслийн домгийн хүүрнэлийн явц дахь хамгийн үндсэн элемент болно. Хүн төрөлхтний үүсэл гарлын домог ба угсаатны үүслийн домогт хүмүүн нь тотемын амьтан, бодистой шууд бэлгийн харьцаа үүсч жирэмслэн, хүмүүн төрөлхтөн, овог аймгийн дээдсийг үүсгэдэг байснаасаа тэдгээр тотемын амьтан, бодис нь уул дүрсээ хувиргаж, хүний дүртэй болж сая хүмүүнтэй ураглаж амьдрах болсон байдаг. Жишээлбэл, шинжааны өөлдийн “хүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан” үлгэр дэх “чоноос авгай авсан хөвүүн” гэх шидэт үлгэрт, хөвүүнд чоно ээж нь: “хүүхэн минь өдөрт чононд хувилж, шөнөд нь тэгээд мөн биедээ тохирно. Чи дөчин тав хоног болтол хүүхний минь арьсийг битгий авч хая, дөчин таван хоног болоход хүүхэн минь мөн биедээ тохирно” гэж хэлж захидаг. Дээрх жишээнээс үзэхэд, хүмүүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан домгийн мотив хадгалагдаж байснаар барахгүй монголчуудын тотемын амьтан нь уг дүрээ хувиргаж сая хүмүүнтэй урагладаг нь ил тодорхой харагдаж байна.

Хүмүүн хийгээд өөр төрөлтөнтэй урагласан мотив нь явган үлгэрт уламжлагдахдаа хүн төрөлхтний үүсэл гарал ба угсаа овгийн үүслийг тайлбарлах, домогт ураг хуримын гол цогц болж байснаас хүн хийгээд ондоо төрөлтөн урагласан мотивт үлгэрт гол цогцын байр сууриа алдаж бусад хэд хэдэн мотивтой нийлж нийлмэл үлгэрийг бий болгосон байна. Жишээлбэл: Шинжааны өөлдийн шидэт үлгэр дэх “Эргүү мунхаг хаан” (тод) гэх үлгэрт өнчин хөвүүн тэнгэрийн хааны хөвүүний хэлсэн ёсоор тэнгэрийн чоно охинтой айл гэр болсноор яригддаг. “Эргүү мунхаг хаан” гэдэг үлгэр бол Дин Най дүнгийн товъёгийн 400D номерт жагсаагдаж байгаа “бусад амьтнаас хувирсан эхнэр” гэх гэв шинж болон Жинь Рун хуагийн товъёгийн 400D номерт жагсаагдаж байгаа “амьтнаас хувирсан” гэх хэв шинж +DNT465 “гоё бүсгүйтэйгээс болж хал амссан залуу” буюу хун дагинын үлгэрийн хэв шинжтэй нийлж яригдаж байна. Энэ үлгэрт хүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан мотив ба хүчир асуудлыг шийдвэрлэх мотив зэргээр илэрч байгаа нь үлгэрийн гол баатар хүчир асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр гол өгүүлэмжээ болгосон байна. Иймээс хүн хийгээд бусад амьтантай урагласан мотив нь шидэт үлгэрт гол мотив болж байгаа биш, харин нэг зүйлийн өвөрмөц онцлог бүхий мотивоор илэрч байна.

Нийгмийн хөгжлийг дагалдан хүмүүс үзэл ухамсар дээшлэн тухайн домоглог сэтгэхүй балархайшиж, бодит нийгмийн амьдралын сайн сайхан ба муу муухай, хүний ертөнцийн хайр сэтгэл, нийгмийн ангийн зөрчил зэрэг нь үлгэрт тусгалаа олдог. Жишээлбэл: алтай язгуурын хэлт үндэстний хүмүүн

хийгээд ондоо төрөлтөн урагласан үлгэрт олонхдоо чоно, хун шувуу гэх амьтан жигүүртнээр илэрч байдаг. Эдгээр нь тэдний байгалийн орчин тойрон болон ямар нэгэн шүтлэгээс шалтгаалсан байлтай.

Гурав. “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэдэг үлгэртэй холбогдох монгол, түрэгтийн өвөг дээдсийн домгууд

Балар эртний хүмүүс өөрийн овог угсаагаа ямар нэгэн амьтан ургамал буюу амьгүй бодистой холбон ойлгож, түүнийг өвөг дээд ба онгон шүтээн гэж шүтэн бишрэх, дээдлэн үзэх, түүгээр овог угсааныхаа бэлгэ тэмдэг болгодог байжээ. Эртний алтай язгуур хэлтний монгол, түрэг төрлийн үндэстний домог ярианд чоно, буга зэрэг араатан амьтныг тотемын шүтээн болгож үндэстэн угсаатнуудынхаа өвөг дээдсийг шүтсэн агуулга багтахар үл барам домгийн мотивуудыг хадгалж байна.

“Монголын нууц товчоон”-д “Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно ажгуу. Гэргий нь Гоо марал ажээ. Тэнгис далайг гаталж ирвэй. Онон мөрний тэргүүнээ Бурхан Халдунаа нутаглаж төрсөн Батцагаан ажгуу” (МНТ, 1981:1) гэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь “Монголын нууц товчоон”-д гарч байгаа өгүүлэмж доторх Бөрт чоно, Гоо марал бол домгийн сэтгэхүйгээр бүтээгдсэн тотемын дүр, эртний умардын нүүдэлчин аймгийн дотор өргөн дэлгэрсэн чоно, буга тотемын тухай домог мөн.

Монголчуудын чоно, буга тотемын ойлголтыг зөвхөн бичгийн зохиол дахь тэмдэглэлээс үндэслэх биш, аман уламжлалаас ч тодорхой ойлгож болох юм. Монголчуудын дунд чоно, бугын тухай аман уламжлал маш өргөн дэлгэр тархсан байдаг. Жишээлбэл: Өөлд монголчуудын дунд уламжлагдсан нэгэн домогт: “Эрт галавын үед, ертөнц дээр монгол хүн гэж байсангүй, амьтай голтой хүн ч байсангүй, гагцхүү амьтан, ургамал л байж гэнэ. Нэгэн өдөр гэнэт тэнгэрээс цагаан гэрэл сацрав. Тухайн гэрлээс нэг эрэгчин хөх чоно бууж иржээ. Тэр чоно өргөн талаар яван явсаар нэг мөрний хөвөөнд хоо маралтай уулзав. Тэгээд хөх чоно, хоо маралтай хамт амьдарч, тэр хоёроос чоно шиг эрэлхэг үр хүүхэд үржээд монгол хүмүүн болсон гэнэ” (Мандах, 325) гэж домоглодог. Энэ тухай Мандах профессорын “Монгол түрэг хэлтнүүдийн угсаа гарлын домог ярианаас сэдэвлэх нь” (ӨНШУС, 1996 оны 3 дугаар хугацаа) өгүүлэлд хиан, нүгүс, урианхай, хонгирад зэрэг эртний овог угсааны ирэл гаралтай холбогдох “Эргүнэ хунгийн домог”-ийг түрэг хэлтнүүдийн домогтой харьцуулан шинжлээд, түүнийг эртний умардын аймаг угсаа, ялангуяа монгол түрэг хэлтнүүдийн дотор өргөн дэлгэрсэн чоно тотемын домог ярианы хувилбар гэсэн үзлээ дурдсан байна.

Түрэг төрөл хэлт үндэстэн угсаатны дотор чоно тотемын домог болон түүний хувилбар нь уламжлагдаж бий. Жишээлбэл: Нийтийн он тооллын өмнөх XVI, XVII зууны үед, түрэг хэлтэн үндэстний дунд шидэт чоно, авран тэтгэсэн домгийн тухай дэлгэрч байжээ. Жишээлбэл: “Шидэт чоно уйгурчуудыг аварсан нь” гэдэг домогт: “Нэг удаа уйгурчууд бусад аймагт ихээр ялагдаж байсан гэнэ. Тэднүүс нэг уулын бэлд дайсанд бүслэгдэж зулж гаргах зам үгүй, бүгдээрээ

үгүй болох аюул тулгарчээ. Энэ үед уулын зүг нэг чоно ирж байхыг үзээд, үхлийн даваанд хүрсэн уйгурчууд энэ чонын араас дагаад явж байсаар уулын хормой дахь агуйд чоныг дагалдан оров гэнэ. Тэдэн бүгдээрээ таг харанхуй агуй дотор явсаар удаан болов гэнэ. Тэгээд чоно тэднүүсийг дагуулсаар агуйн нөгөө талд нь хүрэхэд нүдний өмнө гэрэл тусч, гэрэл гээтэй өвс бэлчээр өтгөн сахлаг, өнөр баялаг тансаг тал газар үзэгдсэн гэнэ” гэх мэтчилэн шидэт чоно, уйгурчуудыг үхлийн даваан дээр байхад нь аварснаар өгүүлдэг. Тэр үеэс эхлэн уйгурчууд чоныг эрхэм дархан ид шидтэй хувилгаан амьтан гэж шүтэн бишрэх болсон гэнэ (转引满都呼主编: 1997: 41; Намжил, 2010: 38) гэхчлэн домоглодог. Тус домгийг цуглуулан эмхэтгэсэн нь хожуу үед хамаарна. Түүний доторх домгийн сэтгэлгээ нь илэрхий балархайшсан байдалтай байдаг.

Мөн энэ мэтчилэн казах үндэстний найман аймагт шидэт чоно авран тэтгэсэн тухай домог уламжлагдаж байдаг. Тухайлбал, казахуудын “Эргүнэ кун найманчуудын домог яриа”-д: “Эрт урд цагт, Алтай уулын энгэрт нутагшиж байгаа найман аймгийнхан бусад аймагт гэнэтээр уулгалагджээ. Дайсан алж хядан, булаан дээрэмдэж, тэр аймгийг хядан дуусгаж, нэг л хөгшин баатрыг үлдээжээ. Дайсан түүний дөрвөн мөчийг нь тасдан хээр хаяад ичгүүртэй үхүүлэх гэв. Гэтэл дайсан яваад тийм ч удалгүй нэг өлөгчин чоно хүрч ирээд баатрын шархыг долоосонд шарх нь түргэн эдгэрсэн байна. Өлөгчин чоно баатрыг Алтай уулын нэгэн асга хадны доорх агуйд дагуулан одож, эр эм бололцон амьдарчээ гэнэ. Сүүлээр нь тэдэн хоёроос үр хүүхэд үржин, нэгэнт устах шахсан овог аймаг нь дахин дэгжрэн хөгжжээ гэнэ. Өлөгчин чоно хийгээд хөгшин баатрын бие далдалж амьдарсан агуй нь “Эргүнэ кун” гэдэг уулын оргилд байдаг болохоор хүмүүс эдгээр найманчуудыг “Эргүнэ кун найманчууд” гэдэг болж гэнэ (转引自毕村, 1992:113; Намжил, 2010: 40). Тус домог дахь өгүүлэмжүүд нь дээр өгүүлсэн “Эртний түрэгийн үүсгэгч дээдэс шидэт чоно” гэх домогтойгоо адилхан яригдаж байдаг. Дээр дурдсан домгуудад эртний хүмүүсийн домгийн ойлголт багасаж, хожуу үеийн нийгмийн хүмүүсийн үзэл сэтгэлгээтэй нэн ойртож ирсэн боловч үүнээс эртний хүн төрөлхтний тотем шүтлэгийн ул мөрийг тодорхой хэмжээнд олж харж болох юм.

Дүгнэлт

Нэгд: Шинжааны өөлдийн “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэх шидэт үлгэр адил бус хувилбараар яригдаж байгаа нь үлгэрийн үйл явдал нь хүмүүсийн дур сонирхлыг татаж чадах эсэхийг шийдвэрлэдэг учир үлгэрчийн үлгэр ярих ур чадвартай холбоотой. Адил бус цаг үе, адил бус соёлын орчин дахь үлгэрч нарын уламжлалаар дамжин, үйл явдлын үндсэн бүтэц нь хоорондоо адилаар буюу адилхан олон хувилбаруудыг бий болгосон байна. Энэ нь даруй түүний аман ярианы шинжээс шалтгаалжээ. Зарим нэгэн үлгэр нь гол үйл явдал байхаас гадна бас биеэ даасан дэд үйл явдлын хэсэгтэй байдаг. Энэхүү биеэ даасан хэсэг нь бас хэзээдээ өөр нэгэн янзын хэлбэрээр бусад үлгэрийн дотор илэрч, бусад үлгэрийн нэг хэсэг нь болж, өөр нэгэн үлгэрийн үйл явдлыг үүсгэдэг. Цаашилбал дан ганц үйл явдалтай үлгэр нь өөр нэгэн хэлбэрээр бусад

үлгэрийн доторх үйл явдлын нэгэн хэсэг болж, нийлмэл шинжтэй үлгэрийн онцлог шинжийг бүрэлдүүлдэг.

Хоёрт: эрдэмтдийн үзэхээр хүн өөр төрөлтөнтэй ураг холбосон үлгэр бол анхандаа тотем шүтлэгээс үүссэн гэж үздэг. Тухайн үед хүмүүс өөрсдийн дээдсээ хүн, амьтан нийлээд гарсан гэж үзэх ойлголт нь явган үлгэрт бодитой тусгагджээ. Нийгэм түүхийн соёлын хөгжилтөөс болж сүүлээр нь хүн амьтантай ураг холбох нь тухайн хүмүүсийн танин мэдэхүйн логикт нийцэхээ больж, үлгэр дахь амьтныг хүн болгон хувиргаж, хүн хүнтэй ураг холбох тухай өгүүлдэг болжээ.

Гуравт: Шинжааны өөлдийн “Чоноос эхнэр авсан хөвүүн” гэдэг үлгэрт ямар нэгэн амьтны арьсаар бэлэг өгөх мотивт монголчуудын эртний шүтлэг бишрэл, чоно тотемын соёл, сүнсний тухай ойлголт зэрэг агуулагдаж байгаа нь тодорхой байна.

Дөрөвт: Хүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан домгийн мотив, хүн хийгээд ондоо төрөлтөнтэй урагласан шидэт үлгэрийн мотив нь хам хэлбэрээр оршиж байна.

Ном зүй

А.Монгол бичгээр:

АМ, (2019). *Алдуурай мэргэн*, Б.Дамринжав эмхэтгэв, Шинжааны Ардын Хэвлэлийн Хороо: [Aiduurai mergen, B.Damrinjav emkhetgeev. Shinjaanii ardiin khevleliin khoroo. 2019]

ДУААҮ, (1992). *Дундад Улсын ардын аман үлгэрийн Шинжааны эмхэтгэлийн Хажин шианий ардын аман үлгэрийн хуваарь эвхмэл (тод)*, Хажин шианий ардын аман зохиолын эмхэтгэлийг найруулан хянах комисс, 5 сар. [Dundad ulsiin ardiin ulgeriin Shinjaanii emkhetgeliin Khajin shianii ardiin aman ulgeriin khuvaari evkhemel (tod). 1992]

Мандах, (?). *Монгол аман соёл судлал*, Үндэстний Хэвлэлийн Хороо, [Mandakh. Mongol aman soyol sudlal. BNKHAU: undestnii khevleliin khoroo]

МНТСТ, (1981). *Монголын нууц товчоон сийрүүлэл тайлбар*, Баяр буулган тайлбарлав. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн хороо: [Mongoliin nuuts товchoon siirüülel tailbar. Övör mongoliin surgan khümüüjliin khevleliin khoroo. 1981]

Намжил, Г. (2010). *Монголын эртний утга зохиолын судлал*, Төвийн Үндэстний Их Сургуулийн Хэвлэлийн Хороо: [Namjil, G. Mongoliin ertnii utga zokhioliin sudlal. Töviin undestnii ikh surguuliin khevleliin khoroo. 2010]

ӨНШУС, (1996). *Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан, сэтгүүл*, 3 дугаар хугацаа. [öväör mongoliin niigmiin шинжлэх ухаан, сэтгүүл, 3 дугаар khugatsaa. 1996]

Тие Ань, (2007). *Монгол ардын увдист үлгэрийн хэвилийн судлал*, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо: [Tie Ani. *Mongol ardiin uvidast ülgëriin khëvshliin sudlal*. Öväör mongoliin ardiin khëvleliin khoroo. 2007]

ХТ, (1991). *Хан тэнгэр сэтгүүл*, 4 дүгээр хугацаа. [*Khan tenger*. Setgүүл. 1991]

Б.Хятад хэлээр:

转引满都呼主编, (1997). 中国阿尔泰语系诸民族神话故事, 民族 版社:

转引自毕树, (1992). 哈萨克民间文学概论, 中央民族学院出版社,



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.